

МАХН-ын Төв Хорооны УТТ-ны гишүүн Т. Рагчаатай хийсэн ярилцлага

Энхбаатар /цаашид Э/: Намын Тх-ны 3-р бүгд хурлаар гарсандаа тиймээ? Тийн тэгээд одоо танаас бол одоо 1984-1991 оны хоорон дахь 84-87 оны хоорон дахь улс төрийн үйл явц 87 онооё хойшхи 91 оны хугацаан дахь бас л улс төрийн үйл явц таны ажиллаж байсан өндөр насны тэтгэвэрт гарсан хойних ч гэсэн үзэл бодол ер нь бодож явдаг санаж явдаг тэр үед юу бодож байсан санаж байсан талаар хуурч хөөрөх маягай ярилцлага аваад тэр хоорондоо би нэмэлт юмаа тодруулаад явнаа гэсэн зорилготой ярилцлага авах гэсэн юмаа.

Та анх хэдэн онд намын ТХ-ны аппаратанд орсон бэ?

Рагчаа /цаашид Р/: би 1954-1958 онд МУИС-ын ЭЗС-д суралцаад 1959 оноос засгийн газар төлвөлөгөөний комиссын 1-р орлогч даргаар ирсэн. Тэгээд би их сургуульд 3-р курсээсээ эхлээд нөгөө бүртгэлийн тэнхим нягтлан бодох бүртгэлийн дунд мэргэжлийн нягтлан бодох байсан. Тэнд дээд боловсролын төлөвлөгөөний яахдаа нягтлан бодох бүртгэлээ давхар үзээд гарсан. Тэгээд тэндээ багшлаад 3-р курсээсээ тэгээд байж байгаад 58 онд төгсөх дээрээ зэрэг намайг энэ улсын төлөвлөгөөний комиссын 1-р орлогч даргаар энгээд ажилуулсан. Тэгээд 87 он хүртэл 1960 оны 4 сарын 1-ээс Улсын төлөвлөгөөний комиссын жинхэнэ дарга бөгөөд СнЗ-ийн орлогчоор томилогдоод. Энгээд би төлөвлөгөөний комиссоод 10 жил ажилаад тэгээд СнЗ-д дангаар бусад яам газруудыг одоо худалдаа хөдөө аж ахуйн чиглэлийн бүх салбаруудыг хариуцаад энгээд ажилаад нийтдээ эн төрийн байгууллага улсдаа 51 жил ажилласны 20 жилийн дандаа худалдааны байгууллагад гадаад худалдаа дотоод худалдаанд нягтлан бодох, хэлтсийн дарга, орлогч дарга гээд янз бүрийн юм хийгээд цаад 31 жилийг нь жинхэнэ төрийн байгууллагат ажилласан. Энэнээс нэг жил хагасыг нь дээд сургуульд багшлаад тэгээд явсаар байгаал 70 настайдаа гарсан нь тэрлдээ. Яахвээ олон жил янз бүрийн байгууллага салбар газарт хөдөө гадаа ажилаад тэгээд хий гэсэн юмнуудыг нь хийгээд тэгээд болж байна бүтэж байна гээд тэрүүхэндээ жаахан дэвшээл энгээл ажилаад байсан ухааны юм болсон хэрэглдээ. Сүүлд пенсенд гарахаасаа өмнө урьд СнЗ-ийн орлогчоор хэд хэдэн яам газруудыг дагнаад хариуцаад ажилласан. Тэгэхдээ Намын ТХ-ны УТТ-д ороод УТТ-ны жинхэнэ орлогч гишүүнээр 15 жил ажилласан. Их удцан хэрэг энэ УТТ-ны ярианы хувьд бол. Би өөрийнхөө намтрыг бичсэн. Энгээл ажилаад тэтгэвэрт гараад 20 гаран жил болчлоо. Энд бол яахав нэг радиотай тэрнийгээ чагнаад энэ нийгэм хөгжил энэ төр засгийн байдал ямархуу янзтай байдгийн байна гэдгийг энүүгээр ярьсныг жаал зугаа юм сонсчоод энгээд байж байх юм.

Э: За та бол 1984 онд УТТ-ны гишүүн бөгөөд СнЗ-ийн орлогчоор ажиллаж байсан байнашдээ тиймээ.

Р: 87 он хүртэл

Э: Тийн ерөнхийдөө 84 он гэхэд 84 онд чинь намын ТХ-ны ээлжит бус 8-р бүгд хурал болоод Бал дарга буулаа шүүдээ албан тушаалаасаа. Тэгээд таны тухай бичсэн нэг номон дээрээс уншсан юмаа. Таныг 84 онд намын ТХ-ны бүгд хурал болоод Бал дарга чинь

оросод байхад Москвад байхад энчээ өөрийг нь албан тушаалаас нь буулгах шийдвэр гарлаа шүүдээ тиймээ. Тэгээд Цэдэнбал даргаар өөрөөр нь зөвшөөрүүлэхэд таны оруулсан хувь нэмрийг ихээ таныг зөвшөөрүүлж чадсаан гэж тэгж бичсэн байхын билээ. Тэр тухайд одоо ярьж болох уу?

Р: Үнэн.

Э: Та тэр тухайгаа толруулж яриач сонин санагдаад байгаан.

Р: Эндээс гурван хүн томилсон юм. Моломжамц Намын ТХ-ны нарийн бичгийн дарга, дараа нь Намсрай мөн нарийн бичгийн дарга төв хорооны хэлтсийн дарга байж байгаад нарийн бичгийн дарга болсын. Би СнЗ-ийн орлогч бөгөөд УТТ-ны гишүүн. Цэдэнбал дарга энэ учрыг бүгд хурал хуралдуулна таныг ажилаас чөлөөд одоо эх орон ард түмэндээ их юм гүйцэтгэсэн бүтээсэн энэ гавьяаг чинь дурсаж тэмдэглэнэ. Амьдралын ажилын шаардлага таныг улс их ийм болчлоо шүү гэдгийг тайлбарлаж таниулаад ирээ гээд явуулсан. Тэгээд Москвад очоод намайг засгийн газрын буудалд Советский гэдэг буудалд буулгачлаа. Нөгөө хоёр төв хорооны буудалд буулгасан. Тэгээд утсаар ярилцаж байгаад тэгээд өнөөдөр л гээд нэг өдөр тогтчоод Цэдэнбал даргын байж байгаа тэр больниц ер гэр айлын байдлаар байлгадаг больниц байдгийн байналээдээ. Тэнд очоод эхлээд Моломжамц суучлаа дараа нь би суучлаа дараа нь Намсрай суугаад дарга тэгээд мэнд мэдчихээд Цэдэнбал даргын авгайг өөр тийш нь лавтай нэг 4-5 цаг тэр больницад авгай нь хамт байсан хэрэг шүү гэр маягийн больниц шүү ирүүлэхгүйгээр тохирчихсон зөвлөлтийхөнтэй. Одоо хүрээд ирчвэл бидний яриаг сонсоод зэвүүцнэ дургүй нь хүрнэ нервтэнэ. Нэлээд адиар ааштай хүн шүү тэр авгай нь. Тэгээд эхлээд Моломжамц ярьтал Цэдэнбал дарга чинь ууралдаггүй жигтээхэн догшин омог зан гаргадаггүй хүн байсын юу гэнээ гэж хэлээд Моломжамцыг заамдаад авсан шүү. Чиний авгай та хоёр л энэ ажлыг хийж байгаа. Чиний авгай чинь зөвлөлтийн гахайнаасаа эхлээд аль байдаг чадлаараа хараадаг зүхдэг тийм хүн гээд л ер нь бишдэхнээ. Тэхлээр нь би Намсрайд за чи гараад хүлээгээд байж бай гээд нөгөө Цэдэнбал даргын гарыг тавиулаад Моломжамцыг гарч бай гээд дохиод хойноос нь би гарлаа. Дахиад хэрэггүй гээд тэгээд л гараад явчлаа бид. Гараад тэр хоёр төв хорооныхоо зочид буудалруу явцан. Би СнЗ-ийн зочид буудалд. Тэгээд миний буусан өрөөнд монгол хариуцсан төв хорооны тасгийн эрхлэгч орос тэр нэр нь сайн орж өгөхгүй байнаа төв хорооны монгол хариуцсан тасгийн эрхлэгч ирцэн байж байна. Монгол хэл устай тэгээд сонирхоод бид ч ажил бүтээсэн юм байхгүй тэгээд иймэрхүү эвгүй юм болоод буцаад ирлээ шүү гэсэн. За тэгвэл тэр авгайг нь гэрт очуулахгүй байх талаар би зохих хүмүүстэй ярьчихлаа. Цэдэнбал дарга одоо яг ганцаараа байж байна. За чи Цэдэнбал дарга дээр очиж ийм учир явдал гарсан шүү гэдгийг нь хэл. Би чмайг энд хүлээгээд чамайг иртэл хүлээнэ шүү. Тэгээд би дор нь буцаж гараад яг тусгай машин үйлчилж байсан суугаад буцаад хүрээд ирлээ. Овоо гайгүй тайвн болчихсон байж байна. За би энгээд буцаад хүрээд ирлээ. Уг нь бидний ирсэн зорилго бол танд энэ юу ойлгуулах таны зөвшөөрлийг авах ийм учиртай юмсан. Тэгээд эвгүйтээд жаахан ширүүн хэлчихлээр зэрэг бүгд гараад явчлаа. Тэгээд би ганцаараа ирж байгаан гэсэн. Аан за гэхихээд босоод

тэр стол дээрээсээ өдийхөн яг энэ алгын хэрээтэй цаас аваад хэдэн юм бичээд над өглөө. Тэгээд МАХН-ын ТХ-ны ерөнхий нарийн бичгийн даргаар нөхөр Батмөнхийг тавих нь зүйтэй шүү гэж хуучин монголоор тэр алгын чинээ цаасан дээр бичээд Цэдэнбал гээд өгчлөө. За одоо би энэнийг авснаас хойш энд байж байх шаардлагагүй. Тэгээд баярлалаа танд сайн сайхныг хүсье гэж хэлчээд гараад явчлаа. Тэгээд ирсэн нөгөө нөхөр сууж байна. Нөгөө юмаа үзүүлсэн за чи наад юмаа өгчих би орой юмуу маргааш өглөө авчраад өгье гэлээ. Тэндээ аваачаад нөгөө хуулаад авсан хэрэг байхлдаа. Тэгээд би бодохгүй юу Цэдэнбал ийм бичиг өглөө гэж монгол нөхөддөө одоо хамт явж байгаа нөхөддөө ч хэлэхгүй очоод ч хэлэхийн хэрэггүй юм байна. Хараа ч энэ одоо эгзэгтэй асуудал гараад ирж байна шүү. Нөгөө бичгээ хамаагүй хүнд үзүүлэхгүй гэж яагаад гэвэл Цэдэнбал даргатай уулзахаас урьд өдөр нь Горбачевийн өрөөд тэр зөвлөлтийн хоёр гурван нарийн бичгийн дарга хэд хэдэн сайд дарга нар арван хэдэн хүн цуглачихсан бид гурвыг хүлээж аваад үүдэн дээрээ тасалгааныхаа үүдэнд горбачев зогсож байгаад хүлээж аваад гар бариад за нагаа манай хатан хаан та нарыг их зовоож байна уу? гэж хэлээд гараа барихдаа бид гуравтай энгэж мэндэлж байгаан. Бид гурвын хэн нь ч дугараагүй. Тэгээд суугаад тэгээд яриад эхлэх дээрээ зэрэг л та гурвын ирсэн зорилгыг бид мэдсэн. Бидний саналаар бол Цэдэнбал үнэхээр хүнд өвчтэй ажиллах чадвар байхгүй гэдгийг манай төв хороо засгийн газрын эмнэлэг хариуцаж байгаа Чазев доктор толгойлсон комисс гараад акт гарсан. Тэгээд акт гарсан гэдгийг батлаж хэллээ. Цаашаа ажлын чадваргүй гэдгийг нь хэллээ. Бидний бодож байгаагаар ер нь Батмөнхийг л тавих нь л зүйтэй юм гэдгийг хэлчлээшдээ. Коммунист намын бодлого тодорхой болчлээшдээ. Энэнийг чинь Батмөнх хэд дахин ирсэн хүн москвад биднээс түрүүлж. Биднээс хэн нэгэн хүнийг дагуулаагүй. Ганцхан Батаа гэдэг орчуулагчаа дагуулаад хэд дахин ирсэн шүү. Тэгж төв хорооны нарийн бичгийн даргаар ажиллах хүн бидний санал байгаа шүү гэдгийг ойлгуулчихсан байсан. Тэгсэн биднийг ороод ирэх дээр зэрэг тэгчихээр нөгөө хоёр маань бас мэдчихлээ. Энэ коммунист намын нөхдүүд чинь санал нэгтэй болчихсон юм байна гэж. Нэгэнтээ энгэчихсэн юмыг би Цэдэнбалаас ийм бичиг авсан гэж хэлэхийн хэрэг алга. Хэрэв тэгээд хэлдэг юмаа гэхэд манай зарим нөхдүүд одоо буруу ойлгоно. Энэ Рагчаа Цэдэнбал хоёр нэг нутгийх тийм учраас Рагчаадаа дотночилж зөвшөөрсөн бичиг өгч наад хоёрт өгөөгүй байна шүүгэж. Бас энгээд бидний хооронд эвгүй юм тавигдана гэж бодоод яг нууж байгаад тэр бүгд хурал өнгөрөх дээр зэрэг нөгөөдөхөө гаргаад Намсрайд өглөө нөгөө жижигхэн хуудсыг нь. Энэ намын түүхэнд архивт хадгалагдах учиртай шүү. Намсрай уншаад аан ийм бичиг чухал гээд аваад хадгалсан одоо байж байдаг байх нэг иймэрхүү юм.

Э: Аан за та тэгээд сая нэг сонин юм ярьлаашдээ. Намайг увсых гээд намайг увсых Бал даргатай нэг нутгийх учраас энгэлээ тэглээ гэсэн яриа ер нь төв хороонд юу гэдгийн Бал дарга нэг нутаг усныг нэг аймгийхныгаа авчирч байна гэдэг ч юмуу тийм яриа. Ер нь ард түмний дунд ч гэсэн Төв хороонд Цэдэнбал төв театрт Түмэндэмбэрэл төв цэнгэлдэхэд Баянмөнх гэдэг ч юмуу тиймэрхүү асуудал ер нь байсан уу? Нэг хүнийг дээш нь тавих

дээр зэрэг нутгийхныгаа дээш нь тавилаа талаа гэдэг ч юмуу тийм юм байсан уу? Би энэнийг цааш нь дамжуулахгүйээ.

Р: Тийм өөрий чинь асуудал олон түмнээр мэдэж байгаа сонсчихсон асуудал байнлдаа. Манайханд төв хороонд ч тэр засгийн газарт ч тэр нэг нутгархах бүлгэрхэх явдал байсан. Би энэ явдлыг ажиглчихаад Цэдэнбал даргад хоёр удаа УТТ-нд хоёр удаа мэдэгдэл хийсэн. Жишээлбэл энэ дээр байж байгаа хамгийн том удирдлагууд 8-9 хүн увсых дээд шүүхийн дарга прокурор за тэгээд төв хороо засгийн газар. Энэ ерөөсөө боловсон хүчний бодлого дээр нийтийн санаа сэтгэлд таараагүй нутгархаж байна гэж хэн ч гэсэн санаж бодохоор байдал бий болчихсон байна шүү. Ийм ийм 9 том тушаалтан дандаа увсых байна. Үгүйээ энэ чинь яаж байгаа нь энэв энэ жижигхэн орон цөөхөн албан хаагчтай тэгээд найм ес арваараа нэг аймгаас байна гэдэг чинь сайн ажил бишээ. Энэ дээр янзлаачээ гэж хэлээд нэлээд хэдэн хүнийг нь өөрчлүүлсэн шүү. Наймаг өөрчил би тэртээ тэргүй нэг эдийн засагч юмуу нягтлан бодох хийгээд өөрийгөө борлуулаад байж чаднаа гэж энгэсэн. Намайг өөрчлөөгүй. За тэр тэгээд өнгөрсөн. УТТ-ны нөхдүүд ч ойлгосон бас ер нь зөв юм байна гэдгийг ойлгож миний энгэж хандах нь намч зарчимдаа зохиж байгаа учраас эд нар энгэж арга хэмжээ авч байна шүү гэж саналаа. Тэгээд бас л удсангүй 2-3 жил болоод байж байсан нэг мэдсэн чинь дорноговоос нөгөө том удирдах ажилд чинь 8-9 хүн ороод ирж үгүйээ нөхөд энэ чинь юу болж байнаа тэр нөгөө дорноговийн Лувсан төв хороо сайд нарын зөвлөлд нөгөө Лувсангомбо Жагварал жаал Дүгэрсүрэн эн сайд нарын зөвлөлд тиймэрхүү маягаар 9 том тушаалд улсууд орчиж дахиад Цэдэнбал дарга дээр УТТ-д орлоо би. Үгүйээ энэ та нар энэ боловсон хүчний Ламзав юу хийгээд байнаа Ламзав гэж дорновийн төв хорооны

Э: Боловсон хүчний хэлтсийн дарга

Р: Шинэ хүчний хуучин шинэ хүчний хэлтэс гэдэг байсын дараа нь тэр чинь давхар албан тушаал наын хянан шалгах хорооны 1-р орлогч дарга Лувсанравдангийн орлогч байсан сүүлд нь жинхэнэ дарга нь болсондээ намын хянан шалгах хорооны. Энэ нөхөр л хийгээд байна. Бүр улайм цайм хэлсэн эзнийг нь заагаад. Бас дахиад нөгөөдүүлийг чинь өөрчлүүлж ондоо хүн тавиулж байсан. Ийм удаатай юм. Энэ явдлын үргэлжлэл нь энгээд яриад байвал зөндөө юм гарна. Хэрэг алга яриад байвал новшруулчихна. Цэгцтэй ойлголт өгөхийн тулд хоёр удаагийнхаа ийм явдлыг чамд хэлж байгаа юм.

Э: Тэгээд одоо Цэдэнбал даргыг албан тушаалаасаа буюгаад за оронд нь бас л увсын Жамбын Батмөнх гуай боллоошдээ тиймээ. За тэр ч яахав Жамбын Батмөнх гуай болоод Батмөнх гуай болсноороо ерөнхийдөө ард түмний хувьд та нийт монголчуудын хэмжээнд за тэгээд намын төв хороо СнЗ-ийн хувьд ямар хүлээлт ямар өөрчлөлт болох бол шинэ юм болох бол гэсэн хүлээлт байсан уу? Ямар байсан бол санал бодол одоо нэг арай өөр үзэедээ ч гэдэг юмуу одоо арай дээр болно ч гэдэг юмуу дор болноч гэдэг юмуу хүмүүсийн сэтгэлгээнд тийм байсан байх тэр талаар та хэлэхгүй юу?

Р: За Цэдэнбал дарга эмнэлэг явахаасаа нэлээн урд энд байхдаа намайг дуудлаа. Контортоо үгүйээ энэ намын төв хороонд урдаар хэлтсийн эрхлэгчээр аваад ажлуулж байна Батмөнх гэдэг хүн байна энэнийг л ер нь СнЗ-ийн дарга болгох нь зүйтэй юм шиг байна. Танай сумын хяргас сумын хүн юм байна. Чи мэднэ биздээ гэж байна. Үгүйээ би мэдэхгүй бид нар чинь 10 насны зөрөөтэй би арав ах юм билээ. Намайг тэнж явахад нутагтаа гарсан хүн юм билээ. За нэг ийм залуу байдаг юм гэлээ гэж дуулсан уулзаж учирч байгаагүй. Тэгэхээр би одоо ерөнхий сайдаар таарах хүн таарахгүй хүн гэж хэлэх хатуу үндэслэл алга. Энэ чинь мэдсэн үндсэн дээр итгэсэн үндсэн дээр саналаа хэлэх учиртай. Би одоо мэдэхгүй байж сайн л хүн учраас та нар энгээд нэрийг нь гаргаад дэвшүүлж байгаа юм байлгүй. Харин би тэр их ойрхон төрлийн хүүхдийг нь танина тэр төв аймгийн хэлтсийн дарга нэг хүн байсын. Тэрнийг би таньдгийн тэр удсангүй зүүнд хаана билээ явж байгаад нас барчихсан. Тийн ойр эгч дүүсийн хүүхэд билүүдээ. Би тэгж л хэлж байсан. Тэгээд бас юм гэдэг хачин юмдаа. Энэ манай Батмөнхийг ерөнхий сайд болгоход Рагчаа дарга дэмжээгүй гэдэг шүү. Тэр бас их муу санаатай хүн байнадаа гэж авгай нь хэд хэдэн хүнд ярьсан байдаг юм шүү солиг. Тэгэхлээрээ энэ хүн гэдэг чинь юуг нь олж барихав юуг нь өөрөө өөртөө хадгалаад явхав гэдэг дээр ер нь жолоо алдаж байгаа юм байна шүү. Ер их яримтгай юм сонсомтгой үнэлэлт дүгнэлт жинхэнэ ёсоор хийдэггүй хувиа бодож манай нөхрийг л тэр нэг сумын нэг нутгийн тэр очиж очиж татгалзсан маягтай ялаа гэж байхав гэж наад зах нь авгай нь хүртэл бодох учиртайшдээ. Гэтэл тиймгүй тэр Рагчаа гэж маш муу хүн тэгээд нөгөө Цэдэн-Иш гэж сурвалжлагч байгаадаа манай хяргасын тэдэнд хүртэл очиж хэлсэн байдгийн шүү Батмөнхийн авгай. За тэгэхлээр энэ дотроо нэг хур хоосон хэнийг тавихуу гэдэг дээр жинхэнэ хүнээ олж бүр шалгаруулах аргагүй л нэг ажил хөдөлмөрөөрөө шалгарсан хүнийг олж илрүүлэх тал сул байжээ гэж би боддог. Батмөнх чинь дээд сургууль төгссөн яхавдээ хэд хэдэн газар ажил хийгээд нэлээн мухайдуухан зантай үг цөөнтэй шинийг нэг санаачлаад нудрагатайхан хөдлөөд хамт олныг нэг чангахан сахилга баттай зангидаад явдаг хүн биш байналээ. Хамт ажилаад л би тэгж ойлгосон. Ердөө энэ манай нутаг нь нутаг юм. Гэхдээ бас сургуульд сурсан. Угаасаа хүн нь дэндүү их даруу томоотой. Одоо биднийг чинь дуудаад үг хэлэх гэж байхгүйшдээ СнЗ-ийн дарга байхдаа. Биднээс үг сонсоод за тэр нь болмоор юм тэр нь энэ ч гойргүй байхаа гэж нэг иймэрхүү маягаар ханддаг. Тэгээд их хачин зантай хүн юм билээдээ зөвлөлтөд их олон удаа явсан. Төв хорооноос ч тэр СнЗ засгийн газраас ч тэр ерөөсөө өөртөө туслалцуулах ямар нэгэн ерөнхий сайд юмуу ерөнхийлөгчийн өөр оронд айлчлахдаа тодорхой мэдлэгтэй чадвартай албан тушаалын хүмүүсээр бүрдсэн тийм явдаг шүүдээ. Тэр тэгдэггүй ганцхан орчуулагч аваад явчихдаг. Тэрэн дээрээс бүр боддог юм туйлын сонин хүн вч байнадаа. Тэгээд олны дунд будлиан тариад хов зөөгөөд байхгүй тэгээл нэг төв зантай хүн суугаад байх л иймэрхүү юм байна шүүдээ гэж тэгж ойлгосон. Үнэхээр ч тийм болох нь батлагдсандаа сүүлрүүгээ олон хүн тэгж боддог болсон. За ийм юм.

Э: 84 онд Батмөнх гуай жинхэнэ Бал даргын оронд очоод ерөнхий нарийн бичгийн дарга болоод Содном гуай СнЗ-ийн дарга болоод тэр үед нь намын төв хорооны бүгд хурал

УТТ, СнЗ-ийн хурлаар юм хэлэлцээд шийдэхэд юу болдоггүй юу дутагддаг байсан бэ? Ер нь тэр үед юм шийдэж хийхэд юу дутагддаг байсан бас болж байсан зүйл нь юу вэ гэдгийг өөрийнхөө салбарын хэмжээнд гэдэг юмуу хэлээч.

Р: За Содномыг СнЗ-ийн дарга болгоход асуусаан. Содномыг би нэлээн мэддэг байсын. Нөгөө СнЗ-д сангийн яаманд ажиллаж байсан болохоор би сангийн яамыг нэг хэсэг хариуцаж байсан. Бас л их томоотой. Гэхдээ Батмөнхийг бодвол арай санаагаа түргэхэн илэрхийлээд хэлчихэж чадах тийм нудрагатай. Хүн дуудаад ажил хэргийн талаар сонирхоход өөрийнхөө саналыг өөрийнхөө даалгаварыг өгчихдөг чадалтай хүн. Гэхдээ бүр нэг их зоригтой золбоотой түргэн зантай гавшгайдуу байдалтай биш. Ийм л хүн. Тэгээд би ер нь энгэж ойлгодог болсон сүүлдээ задаа манай энэ Батмөнх өөрөө ийм наазгар томоотой тэгээд одоо Содном бас нэлээн аажуухан зантай тэгээд удирдлага хоорондоо нэг их муудалцаад байхгүй ч гэсэн нэг их нарийн эв дүйтэй улс биш юм байнадаа гэж хатуу ойлгодог болсон би. За яагаад энгэж хатуу ойлгодог болвоо гэхлээр ЗХУКН-ын ТХ-ны ХАА хариуцсан нарийн бичгийн дарга 10-аад хүн дагуулаад манайд ирсэн юм. Ирээд нэг 5-6 хоноод буцах боллоо. Буцах өдөр нь сайн өдөр таарчихлаа. Өнөөх хуучин заншлаараа ЗХУКН-ын өндөр нэр хүндтэй хүмүүсийг нэлээн олон дарга гаргаж өгдөг байсан юм. Тэр өдөр зөвхөн УТТ, СнЗ-ийн орлогчид тэр хүнийг гаргалаа. Нисэх онгоцны буудал дээр очоод байж байтал Цэдэнбал даргын авгай тачигнаад л нөгөө хүний хажууд зогсчихсон төв хорооны нарийн бичгийн дарга тэр нөхдүүдийн хажууд энэ Лувсан гээд Лувсан гуайг заагаад Цэдэнбал даргыг цааш нь харуулж байж л өөрөө оронд нь суух гээд байж байгаа энэ хятадын төлөөлөгч юм шүү гээд авчлаа онгоцны буудал дээр. Үгүйээ бидэнд ер нь ямар хэцүү байв гэвч тэгээд тэд нар ч зовчих шиг боллоо тэгээд онгоцондоо сууя гээд явчлаа. Тэгээд би Лувсанравдан намын хянан шалгахын дарга нөгөөдөх нь Жалан-Аажав хоёрыг тэр бүтэн сайн өдөр учраас бид нар их тэнгэрийн аманд байдаг амралтын газар очиж амардаг байсан. За та хоёр амралтын газар явах бол бид гурвуулаа нэг тэргэнд суугаад явчъя миний тэргэнд суугаад та хоёр тэргээ буцаачихуу гэсэн тэгье гэнэ. Тэгээд их тэнгэрийн амралтаас нэлээн наахан шиг буугаад тэгээд би та хоёрт нэг саналаа хэлэх гэсэн юм. Өнөөдөр Цэдэнбал даргын авгай тэр зөвлөлтийн коммунист намын төлөөлөгчдөд маш муухай үг хэлвээ тэр Лувсан гэж зааж байгаад нөхөд минь иймэрхүү юм газар авхуулж болохгүй шүү. Нэг нь намын ТХ-ны дотоод асуудал хариуцсан нарийн бичгийн дарга нөгөө нь намын хянан шалгах ажил хариуцсан дарга. Энэ авгайд арга хэмжээ авах хэрэгтэй нөхөр Цэдэнбалд ч гэсэн УТТ дээр асуудал оруулж цэгцлэх нь зүйтэй юм шүү гэж хэллээ. Хөөе хөөе Рагчаа гуай надаас олон дүүлдээ энэ намын хэрэгт орно тэр хэрэггүй гэхилээр зэрэг дахиад би тэр хоёрт юм хэлээгүй. Амралтын газар очиж амарч байгаад буцаад явсан. Тэгээд сүүлрүүгээ энэ хоёрт нарийн нандин намын нэр хүндтэй холбоотой юмыг хэлж бодоггүй улс юм байна зөвшөөрөхгүй надад намын нэгдэлд халтай та дугай бай гэж хэлж байхыг бодоход энгээд тэрнээс авхуулаад л аан бид нар чинь дотроо нэг их өөдтэйхөн нэгдэлтэй нэг зорилго намынхаа нэр хүнд намынхаа ажлын төлөө зангидсан гар шиг биш юм байна шүү. Энэ хоёр

болохлоор нүдэн дээр нь өнөөдөр болсон дүрсгүй муу явдлыг хэлж байхад тийм юм бүү ярь гэж энгэж зүрхэлж хэлнэ гэдэг чинь юу гэсэн үг байдгийн бэ.

Хүний ажил дээр математикийн дундажлах гэдэг аргыг хэргэлдэг тэгэхлээр сайн хүний ажлыг дарна гэдэг муухай шүүдээ. Залхуу хүний ажлыг дээш нь татаад хий онгируулна гэдэг чинь ёстой муу шүүдээ. Нэгдүгээрт энэ. Хоёрдугаарт манай статистикыхан ямар нэгэн тоо дүгнэлт эд нар гаргахдаа 180төгрөг 50 мөнгө гэж байгаа бол тэр бутрхай тоог 5-аас дээшийг нь урагш нь нэг болгож 5-аас доош тоог бол хаядаг бас энэ ажлын дүн гаргахад.

Э: Энэ бол тухайн социализмын үед ажлын үр бүтээмжид сөргөөр нөлөөлж байсан зүйлсүүдийн л нэг тиймээ.

Р: Аанхан. Тэгээд юманд илэрхий тодорхой шудрага хандах хандлага үгүй болж байна гэсэн үгшүүдээ. Нөгөө мууг нь дээш нь хий цаасан дээр ахиулаад баярын цаасаар хий сэтгэлийг нь дар нь гэдэг чинь энэ дундажлах арга гэдэг чинь авч хэргэлэхэд тун дэмий арга юм байна шүү. Том улсын олон зуун саяар дэлхийн хэмжээгээр хэрэглэж байгаа статистикийн мэдээнд бол бутрхай тооны 5-ыг ахиулах 5-ыг хаяад явахад бол тэнд гарз хэнд ч байхгүй. Бүх дэлхийн олон миллиард юман дотор нэг аравтын бутархай нэг дөрөв нь байна уу тав нь байна уу ямар хамаатай юм. Хувийн жин гэж байхгүй байхгүйюу. Аан жижиг орны хэмжээнд сумын хэмжээнд багийн хэмжээнд аймгийн хэмжээнд тэр математикийн тэр тоог хачж болохгүй байхаа. Тэр чинь осолтой.

Э: Та Майдар даргын оронд Монгол-Зөвлөлтийн засгийн хоорондын комиссын даргаар очсондоо тээ.

Р: Тийм

Э: Аан за таныг тэр 84 онд москвад очиход хүлээж авч байсан Горбачев ЗХУКН-ны ТХ-ны нерөнхий нарийн бичгийн дарга болоод престоика өөрчлөн байгуулалт гэж юум гаргаж эрээд хэрэгжүүлэх болсон. Энэ бүхнийг МАХН-ын ТХ, СнЗ хэрхэн хүлээн авч хэрэгжүүлж байв. Үүнд таны тэргүүлж байсан засгийн газар хоорондын комисс тодорхой үүрэг гүйцэтгэж байсан байх. Тэр талаар та тодруулж яриач.

Р: За би энэ талаар жаал ярья. Би жаахан эртэхнээс эхлье. Манай бүх ард түмэн зөвлөлтийг их итгэдэг. Зөвлөлтийн сургагч нарыг итгэж бүр багш гэдэг. Ах гэдэг орос хүн байвал манай ах нар гэж ярьдаг. Ийм сэтгэл зүйн ойлголтонд орсондоо. Тэгэхээс ч өөр аргагүй. Ухаан нөгөө зөвлөлтийн ард түмэн Лениний заавраар 1921 онд манай зэвсэгт хүчин манай партизанд дэмжиж гадны нөгөө гоминданыхан хятадын дотоодын хар шар феодалуудын эсэргүүцлийг дарахад туслаж байсан. 1936 онд Японыг халх голоор довтлоход бас дэмжиж байсан зөвлөлтийн цэрэг ирж. За тэгээд элдэв нийгмийн халдварт өвчинтэ байхад бүр 3 жтлээр ирж өөрийнхөө машинтай өөрийнхөө эмтэй эмч нар нь ирж бүх хүнийг эрүүл мэндийн комисст оруулж эмчилж өгсөн өвчнөөс салгасан. Бичиг үсэг мэддэг хүн цөөхөн

байхад олон сургууль байгуулж өгсөн. Өөртөө хүмүүс аваачиж сургасан ийм их сайхан гавьяа дэмжлэгийг бодоод манайхан чинь зөвлөлтийн хүмүүсийг их итгэдэг хайрлдаг болцымдаа үндэс нь. Тэгээд улам монгол орныг эдийн засаг соёл боловсрол шинжлэх ухааны талаар дэмжихийн тулд засгийн газар хоорондын комисс гэдгийг байгуулаад. Тэр комисст хоёр талаас итгэгдсэн хүмүүсээ хоёр намын төв хороо хоёр засгийн газар тавьж байсан юм. Тэгээд манайхаас тийм комисс байгуулаад Майдарыг тавьж байсан юм. Ер нь өдөр тутмын ажилаас эхлээд нөгөө төлөвлөлт нэг жил гурван жил таван жил арван таван жилийн төлөвлөгөөтэй байлаалдаа тэр үед. Тэр төлөвлөгөөг зохицуулж зөвлөлтөөс авах өгөөд байх юм байхгүйлдээ. Худалдануул гэхээс жаал зугаа мал аж ахуйн юм байгалийн гаралтай юм тэрнийг зохицуулах. Дотроо яам газруудаа зрхицуулж байх зөвлөлтийхөнтэй. Тийм л үүрэгтэй ажил хийдэг байсанлдаа. Тэн дээр Майдар нэг их хийгээд барьсан юм ч байхгүй унагаад доошлуулцан юм ч байхгүй зүтгэлээрээ хийдгээ хийгээд л цагаан санаатай тийм ил яриатай хүн. Майдар зөвлөлтийн хүнтэй хэрэлдчихвэл ч хэрэлдчихнэ монгол хүнтэй хэрэлдчихвэл ч хэрэлдчихнэ хэлвэл хэлнэ тиймэрхүү хүн байсан. Тэгээд сүүлд зөвлөлтийхөн арай дэндүүлээд их юм тасдаж авах гээд наймаа жаахан онцгүй болоод тэгээд оронд нь намайг тавьсан хэрэг байнадаа л гэж бодож байсан. Ах дүү хүмүүст ч байдаг шүүдээ мөнгө аваад сурчихсан тэрнтэй адилхан манайхыг тийм болгохгүй бие даалгах юмсан гэж зөвлөлтийхөн боддог манайхан аваад сурчихсан болохоор сая юм өгөөч гэхээр хоёр зуун мянгыг өгье гэхээр үгүй гэж голоод бэлэнчилж сурчихсан эвгүйхэн дугарчихдаг байсан байхлдаа Майдар гэж боддог. Бич бас сүүлдээ улайм цайм үгүйээ нөхдөө та нар социализм гэдгийг байгуулаад биднийг дагуулаад явж байдаг биднийг энэ ядуу зүдүү байхад та нар туслахгүй яадгийн монголчуудаас та нар ер нь социализмын үед өр нэхээд байх юмуу? Үгүй шүү бид нар чинь ихээ баяжиж байж мундаг хөгжилтэй болж байж та нарт өрийг чинь төлөх шаардлагатай. Тэр үеийн социализмын хөгжил нийгмийн зарчим юу гэж хэлнэв тэрний дагуу л явна. Төлчихнөө гэж хэлэхгүй төлөхгүйээ гэж хэлэхгүй гээд би суучихдаг байсан.

Энэ Содном сангийн яамны сайд байхдаа Долгормаа 1-р орлогч нь тэгээд гадаадад тушааж байгаа малын гаралтай түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэтэй зэрэгцүүлэхэд зөвлөлт ямар үнээр авч байна вэ гэдгийг судалсан юм билээлдээ. Судлаад тэгээд зөвхөн зөвлөлтөд худалдаж байгаа мал жил бүр 4-4,5 сая толгой малыг бид зөвлөлтөд худалддаг байсан. Жил бүр шүү. Толгой гэж ярьж байна. Малын өртөг гэхэд л зөвлөлтийн мал импорт гэж энэ ажлыг хариуцсан байгууллага байдаг байсан. Энэ л гэхэд зөвхөн жилдээ 300 сая долларын ашиг олдог гэсэн дүн гаргаад Майдарт сонсогосон юм билээлдээ. Тэгээд тэрнээсээ болоод түүхий эд эд нарыг та нар арай хямдхан үнээр аваад их ашиг олдог жишээ нь малын үнэн дээрээс тодорхой байна гэж хоорондоо ярилцсан юмуудаа. Энэнийг л зөвлөлтийхөн сонссон юмуудаа. Тэгээд зөвлөлтийхөн үгүйээ бид нар чинь ямар үнээр малыг чинь авна тэрэндээ тааруулсан хямд үнэтэй бараа танайд нийлүүлж байсан шүүдээ. Тэгээд танай улсын төсөв чинь экспорт импортоосоо зохих хэмжээний ашиг олно тэгээд явж байдаг шүүдээ гэж зөвлөлтийхөн хариулсан байдаг. Тэгээд энэ зөвлөлтийн сургагч нар хамаг тооцоог хийдэг тэгэхдээ малын үнэ эд нар дээрээс монголд жаахан

ашигтай өөрийх нь улсад илүү ашигтай байх тооцоо хийдэг гээд ойлгоцон юм билээ энэ Содном, Долгормаа, Майдар эд нарт тэгээд тэр яриа нь зөвлөлтийхөнд ажиглагдчихжээ. Тэгэхлээр жаахан дургүй нь хүрсэн. Байдал ямар байсан гэвэл яг үнэн. Одоо яам гэхэд ямны хэлтэс бүр сургагчтай бүх нарийн тооцоо нарийн нандин юмнууд цугаараа тэр сургагч нарын гараар орж засгийн газраар батлагддаг. Тэгэхлээр эх орноо бодох сургагч заавал байж таарнаа. Үгүйээ нэг хонин дээрээс ганц рубль ч гэсэн олоод авах нь хэрэгтэй гэнэ шүүдээ. Тэр тиймэрхүү л бодол дээрээс яриа гараад тэр бодлоо сайн ойлголцож ярилцахгүй тэгэсгээд өнгөрчихдөг байжээ. Тэрнээс болж зөвлөлтийн зарим нөхдүүд хүйтрээд байдаг. Тайлбарлаад ярьсангүйдээ тооцоо ямраар ч гарч болноо зөвлөлтийн талаас өөрөөс эргүүлж асуугаад ярилцахгүй болохоор л ойлголцохгүй буруу ойлголцох байдал гараад байсан хэрэг. Тэр бол үнэн монголчуудад тийм бодол байсан шүү. Бараа таваар өндөр үнэтэй ирээд байнаадаа тэгсэн манай үхэр адуу хонь ямааны үнэ тэгж гайхмаар нэмэгдэхгүй байнаадаа гэдэг ойлголт гарцан. Тэрүүгээр тэр мал импортын 300 сая шилжих рублийн ашиг олдог юм байна гэдгийг Содном Долгормаа эд нараас дам соссон байсан. Үнэхээр машин техник оруулж ирэхлээр хаа хамаагүй өндөр үнэтэй үгүүээ нөхөд энэ чинь яаж болноо нэг суурь машиныг нэг жил 100 нэг жил 110 гээд нэмээд байна. Гэтэл бид нар үхэр адууныхаа үнийг нэмээд байх бололцоо байхгүй. Үнэндээ нэмье гэвэл нэмэх бололцоо байгаа гэдгийг би ажил хүлээж авахдаа хэлсэн.

Э: Би танаас нэг юм асууя. Намын ТХ-ны бүгд хурлууд ямар хэлбэрээр ямар уур амьсгалтай болдог юм бэ? Би 1984-1990 оны хоорон дахь намы ТХ-ны бүгд хурлын материалууд уншсанлдаа. Тэгэхэд тэн дээр нэг хоёр хүн үг хэлээд тэгээд л гарсан шийдвэр нь байх юм. Тэгээд тэр бүгд хурлууд ер нь ямар уур амьсгалтай болдог байсын тэр илтгэлийг шүүмжлэх эд нар гэж байсан уу?

Р: Бид нар чинь ЗХУ-д сургуульд сурсан хүн олон олонтой. Эндээ байгаа хүмүүс нь зөвлөлтийн мэргэжилтнүүдтэй олон жил ажилласан ийм л боловсон хүчинтэй байлаа шүүдээ монгол. Тэгээд тэд нар чинь биднийг бодвол их өндөр мэдлэгтэй боловсролтай чадалтай тэнхээтэй тэгдэг юм шүү энгэдэг юм шүү гэж зааж өгч байгаа болохоороо багш шавийн харилцаа гэдэг их осолтой сэтгэл зүйн их нарийн дотносог гүнзгий нарийн харилцаа бий болчихнээ сэтгэлд тэгээд тэр багш юу гэж хэлнэв за гэж дугарах нь их олон. Зарим юм сэтгэлд таараагүй арай зөрүүтэй юм байхад зүрх гаргаж тайлбарлаж ярьдаггүй. Энэ сэтгэл зүйн энэ чинь манай тэр их хурал бүгд хуралд бүгдэнд нь нэвтрээд заншчихсан. Намын их хурал болвол тэгэхүү нөхөд энэ зүйтэй юу гэхэд өө Цэдэнбал дарга тэгж байгаа бол зүйтэй гээд гар өргөдөг. Бүгд хурал дээр ч тэр зөвшөөрөмтгий өөрийн санлаа үгүйээ байз хүлээж байгаараа надад ийм санал байна гээд ардчиллын тийм нэвтэрсэн зан чанар багатай болдог байсан шүү. Ура Улаан туг л гэж их хашгардаг.

Э: Бүгд хурлаас гадуур энгээд уулзаад ярьж байхад УТТ, СнЗ-хөнтэй уулзаад ярьж байхад Горбачевийн хийж байгаа престоикагийн төлөөр тэрнийг монголд хэрхэх вэ гэдэг талаар хэр ярилцдаг байсан бэ?

Р: Ээдээ бараг ярихгүй шүү. Ер нь ялангуяа ЗХУ-ын талаар Горбачев тэгж байна тэр Хрушев тэгж байна гэж сайн талын юм байвал ярина тэрнээс муу талын юм байвал ярьдаггүй тэр талаар нэгэндээ их хартай ханддаг. Хэд хэдэн улсуудыг энэ туалаар сонсоод аймгийн намын хороо, аймгийн гүйцтгэх захиргаанд арга хэмжээ аваад хашраачихсан байсан байхгүй юу. Энэнийг чинь ил гаргаж ярьж болдоггүй ил гаргаад явбал өөрийг чинь бас хашраачихна. Аймтгай ийм нэг зөвшөөрөмтгий заншил байсан шүү. Ухаа нь тэр ЗХУКН-ын ХХ их хуралд байнаа үндсээр нь престройка хийх хэрэгтэй гээд бичихсэн байгаа. Тэрнийг вах дээрээ зэрэг короная престройка гэдгийг нөгөө холбооны 15 улс байнашдээ тэдэнд чинь ихэвчлэн үндэсний боловсон хүчин хөгжөөд Башкерийх нь башкертэй байна намын хорооны дарга нь СнЗ-ийн дарга нь энгээд заавал жинхэнэ орос хүнийг дээрээ аваачиж тавьдаг үе чинь өнгөрөөд үндэснийх нь өөрийх нь боловсон хүчин хөгжиж ирсэн үед тэр престройка болохоор зэрэг за ойлгож байн шүү тэд за короная престройка үндсээр нь өөрчлөн байгуулна гэж тэгж бичсэн байгаашдээ хурлын тогтоол дээр. Тэгвэл бид ганц ЗХУ-ын бүрэлдэхүүнд байхгүй тусдаа улс болоод энгээд өөрөө өөрийгөө аваад хөгжөөд явья гээд тэгээд ганц Горбачев үлдээд 15 орны төлөөлөгч гарч явчаад маргааш нь очиж тусдаа болсон гэдэг яриа бийшдээ. Тэгэхээр зөвлөлтийн бусад улсад бас оросод итгэдэг мөн багш шавь гэдэг ах нар гэдэг тийм байдлаасаа хөгжөөд оросоос дутахгүй мэдлэгтэй мэргэжилтэй удирдах чадалтай болчихоор үндэсний үзэл санаа гэдэг энгээд хөгжөөд ирнээ тэгээд үндэсний тусгаар бие даасан улс болоод бид аваад явчихна гээд энгээд задраад ирлээ шүүдээ. Энэ нөлөө манайд тэртээ тэргүй халдаж л таараа шүүдээ. Хэрэв тэгээгүй болвол манайхан оросыг дуурайдаггүй байсан бол бид нар социалист байгуулалттайгаа үлдэх байсан. Яагаад гэвэл энэ хятад хойд солонгос вьетнам куба энэ дөрөв дэлхийн хүн амын 40 гаран хүн ам хувийг нь социализмтай байж байншдээ. Хятад одоо ноднин бид дунд зэргийн чинээлэг амьдралтай социалист орон гэдгээ заралчихлаашдээ. Одоо өвөр монголын радио сонсож байхад нийгэм журам социализм гээд авч байдаг дандаа. Тэгээд хятадад итгэдэггүй нөгөө зөвлөлтийхөн хятадад муудахаар дагаад муудчихсан тэгээд хятадад байж байгаа юмыг өөр дээрээ жишиг болгоод аваад хэргэлсэнгүй. Одоо манай зарим хүмүүс социализм устаж үгүй болсон зөвлөлтөд байсан социализм устсан гүйцээ шүүдээ гэж үгүйдээ цаана чинь хятадад тэр дөрвөн улс байна шүү гэж би яриад байдаг. Социализмыг эд нар аваад явж байнашдээ.

Э: 80-аад оны дунд үеэс утга зохиол урлагийн салбарт түүхэн болоод шүүмжлэлт уур амьсгал бүхий бүтээлүүд гарах болсонлоо. Энэ нь ард иргэдийн үндэсний ухамсар сэргэх шүүмжлэлт уур амьсгал хөгжихөд нөлөөлсөн. Тэгэхээр тэр үзэл суртлын зэвсэг болсон сонин хэвлэл утга зохиол урлагийн салбарт тавьж байсан хяналтаа намын зүгээс сулруулсан юмуу эсвэл бодлогоор энэ бүгд хийгдсэн юмуу?

Р: Энэ бол зүгээр ялангуяа намын үзэл суртал ухуулгын ажил гэдэг чинь туйлын их хүчтэй явдаг бүр баг өрх айлуудаас эхлээд тэр багийг хариуцсан өрх айлуудыг хариуцсан ухуулагч байсан байхгүй юу хааяагүй. Энгээд ардчилал зах зээлийн нийгэмд шилжлээ тэгээд заралчихлаар намын үзэл суртлын ажил бүр байхгүй. Бие даасан байгууллага

байхгүй болоод яагаад байхгүй болвоо гэхээр хэвлэл эрх чөлөөтэй болоод зөндөө хэвлэл радио телевиз энэ байж байхад дахиад юун үзэл суртал тэгэхээр намаас бие даалгаад яриад байх шаардлагагүй болчлоо гэдэг ойлголтонд хүрчихгүй юу цөмөөрөө. Одоо аймаг суманд хүртэл нам удирддаг байлаашдээ. Үндсэн хууласаа нам удирдана гэдгээ авч хаяад тэгэхээр зэрэг нөгөө ардчилал гэдэг юм эрх чөлөө гэдэг юм энгээд болж байгаа бид өөрсдөө энэ хэвлэлээ уншаад тэр телевизээ сонсоод энэ радиогоо сонсоод тэртээ тэргүй төр засгаас явуулж байгаа бодлого намаас явуулж байгаа бодлого юмаа мэдчихнэ гэж энгээд ирсэн хэрэг.